



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН
САЙД С.ОЮУН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 9/ВГ/ГАГ 01/17

Гэрээний хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай

БОНХС таны багцад хамаарагдах "Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн"-д аудит хийх явцад Гэр хороололын айл өрхөд "60-80 м² хүртэл талбай халаах, усан халаалттай сайжруулсан зуухыг худалдан авч нийлүүлэх" тендерийг НЗДТГ-аас шалгаруулж, "Хүрд" ХК-тай 20,000 ширхэг зуухыг 11,095.9 сая төгрөгөөр нийлүүлж, суурилуулах ажлыг 2012 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан 3,328.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон байна.

Гэрээг хугацаанд нь хэрэгжүүлэх боломжгүй болсон тул гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 2013 оны 6 дугаар сарын 25-ны дотор нийлүүлэхээр сунгалт хийж, Нийслэлийн агаарын чанарын албаны дэд дарга Х.Гальмбек, "Хүрд" ХК-ийн ерөнхий менежер Б.Бат-Эрдэнэ нар гарын үсэг зурж, Нийслэлийн агаарын чанарын албаны дарга Ч.Батсайхан, "Хүрд" ХК-ийн захирал Б.Энхжаргал, НЗДТГ-ын СТС-ын хэлтсийн дарга Э.Ганхүү нар баталгаажуулж гарын үсэг зуржээ.

"Хүрд" ХК нь 2012 оны 10 дугаар сарын 24-ны өдрөөс 2013 оны 1 дүгээр сарын 23-ны хооронд нийт 6248 ширхэг усан халаалттай сайжруулсан зуухыг улсын хилээр оруулж ирсэн бөгөөд үүнээс 2013 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 511 ширхэгийг айл өрхөд суурилуулсан гэх боловч ажлын гүйцэтгэл албан ёсоор гаргаагүй, БОНХЯ-нд ч ажлын гүйцэтгэлийг ирүүлээгүй байна

Гэрээ байгуулагдсанаас хойш 9 сар гаруй хугацаа өнгөрөөд байхад нийт нийлүүлэх 20,000 ширхэг зуухнаас дөнгөж 31.2 хувь нийлүүлэгдээд байгаа бөгөөд гэрээний хугацаа дуусахад 3 сар гаруй хоногийн хугацаа үлдэж байгаа нь энэ ажлын явц удаашралтай байгааг харуулж байна.



Иймд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хийгдэж, 2012 төсвийн тухай хуулиар батлагдсан олгогдоогүй байгаа үлдэгдэл болох 7,767.1 сая төгрөгийн үнэ бүхий 14,000 ширхэг усан халаалттай сайжруулсан зуухыг 3 сарын гэрээний хугацаанд нийлүүлж чадах эсэх асуудлыг судлаж, цаашид санхүүжилт хийх эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

БОНХЯ, НЗДТГ, НАЧА-наас агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хийгдэж байгаа усан халаалттай сайжруулсан зуухыг нийлүүлэх, суурилуулах ажлын явц байдал, түүний үр дүн, чанар байдал ямар байгаа, дээрх төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх хугацаа нь бодитой эсэх асуудалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх,

075547

Хэрвээ БОНХЯ, НЗДТГ, НАЧА-наас хэрэгжүүлж байгаа дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл 11 137,0 сая төгрөгийн өртөгтэй энэ ажлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, ажлын явц байдал, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллан, уг ажлыг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлж 2013 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг БОНХ-ийн сайд С.Оюун, НЗД-ын орлогч Ж.Бат-Эрдэнэ, ЗДТГ-ын СТС-ын хэлтсийн дарга Э.Ганхүү, НАЧА-ны дарга Ч.Батсайхан, Гүйцэтгэгч "Хүрд" ХК-ийн захирал Б.Энхжаргал нараас **ШААРДАЖ** байна.

Албан шаардлага

Бичсэн:
Үндэсний аудитын газрын ГАГ-ын
ахлах аудитор

Г.Цэдэнбалжир
Нийцлийн аудитын газрын аудитор
Э.Уянга
УХА0122


Танилцаж, зөвшөөрсөн:
Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
С.Оюун
Нийслэлийн Засаг даргын орлогч
Ж.Бат-Эрдэнэ

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга

Д.Цэцгээ
НЗДТГ-ын СТС-ын хэлтсийн дарга
Э.Ганхүү
НАЧА-ны дарга
Ч.Батсайхан
"Хүрд" ХК-ийн захирал
Б.Энхжаргал

